

**“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР**

2023 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр

№ 23/01

Улаанбаатар хот

**Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн
тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай**

“ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцаж, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-өөс өгсөн дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн дээр Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.8 дахь заалт, 2023 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар “Хангалттай” гэж дүгнэсэн Компанийн ТУЗ-ийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрч баталсугай.



**“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР**

2023 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр

№ 23/02

Улаанбаатар хот

**Төлөөлөн удирдах зөвлөлийн
гишүүдийг улируулан сонгох тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дах заалт, 77 дугаар зүйлийн 77.1 болон 77.2 дахь хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.7 дахь заалт, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг, 2023 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дараах гишүүдийн бүрэн эрхийн хугацааг 1 (нэг) жилээр сунгаж, улируулан сонгосугай.
 - 1.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн Ердийн гишүүн:
 - 1.1.1. Монгол Улсын иргэн Очирсүрэн овогтой Болдбаатар
 - 1.1.2. Монгол Улсын иргэн Володъя овогтой Баярсайхан
 - 1.1.3. Монгол Улсын иргэн Сэнгээ овогтой Энх-Амгалан
 - 1.1.4. Монгол улсын иргэн Баатархүү овогтой Хос-Эрдэнэ
 - 1.1.5. Монгол улсын иргэн Цэрэндорж овогтой Ууганбаяр
 - 1.1.6. Монгол улсын иргэн Болд овогтой Итгэл
 - 1.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн Хараат бус гишүүн:
 - 1.2.1. Монгол Улсын иргэн Сүрэнхүү овогтой Боргил
 - 1.2.2. Монгол Улсын иргэн Жигдэн овогтой Жаргалсүрэн
 - 1.2.3. Монгол Улсын иргэн Даваасамбуу овогтой Галхүү
2. Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, Компанийн дүрэм, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам болон бусад Компанийн засаглалын журмуудыг мөрдөж ажиллахыг улируулан сонгогдсон Төлөөлөн удирдах зөвлөлийн Ердийн болон Хараат бус гишүүдэд үүрэг болгосугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга (Б.Оюунболд)-д даалгасугай.



**“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР**

2023 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр

№ 23/03

Улаанбаатар хот

**Төлөөлөн удирдах зөвлөлийн
2023 оны төсвийг батлах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.11 дэх заалт, 2023 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны төсвийг энэхүү тогтоолын Нэгдүгээр хавсралтад заасны дагуу баталсугай.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны төсөвт хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад даалгасугай.





“ЛэндМН БЭСБ” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн
2023 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн ээлжит хурлын
23/03 тоот шийдвэрийн 1-р ХАВСРАЛТ

**ЛЭНДМН БЭСБ ХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТӨСӨВ**

No	Зардлын зүйл	Гишүүдийн тоо	Сарын цалин (төгрөг)	Сар	Нийт төсөв (төгрөг)
1	Цалин урамшууллын төсөв	10	10,600,000	12	143,100,000
1.1	Дарга	1	1,500,000	12	18,000,000
1.2	Хорооны дарга	3	1,200,000	12	43,200,000
1.3	Гишүүн	5	1,000,000	12	60,000,000
1.4	Нарийн бичгийн дарга	1	500,000	12	6,000,000
1.5	НДШ-ийн зардал				15,900,000
2	Хурал болон бусад зардал				10,000,000
	НИЙТ ТӨСӨВ				153,100,000

**“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР**

2023 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр

№ 23/04

Улаанбаатар хот

Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.1 дэх заалт, 2023 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

1. Компанийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.2.9 дэх заалт буюу “Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх” үйл ажиллагааг Компанийн дүрмээс хасахаар шийдвэрлэсүгэй.
2. Энэхүү шийдвэрийн 1-т заасантай холбогдуулан цаашид энэхүү үйл ажиллагааг эрхлэхгүй байхыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д даалгасугай.
3. Энэхүү шийдвэрийн 1-т заасан нэмэлт, өөрчлөлт оруулсан Компанийн дүрмийг энэхүү шийдвэрийн хавсралтаар баталсугай.
4. Энэхүү шийдвэрийн дагуу батлагдсан Компанийн дүрмийг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу улсын бүртгэлд бүртгүүлэх, тийнхүү бүртгүүлэхтэй холбоотой аливаа арга хэмжээг авч хэрэгжүүлэх, дүрмийн хувийг Санхүүгийн Зохицуулах Хороонд хүргүүлэхийг Компанийн Хууль хянан нийцүүлэлтийн мэргэжилтэн (Х.Одончимэг)-д үүрэг болгосугай.
5. Энэхүү шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дарга (О.Болдбаатар)-д даалгасугай.

